



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 467

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны “Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл тооллогын ажил зохион байгуулах тухай” а/200 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ц.Энх-Амгалан (Татварын байцаагч)

Э.Бямбасүрэн (Ахлах зохицуулагч, Цагдаагийн ахмад)

Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Д.Нансалмаа (Татварын байцаагч)

2. Сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчийн үйлчилгээний газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулан үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж, тайлagnаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ



401100133